



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/Н/Ч

Арвайхээр

Г Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.2.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/102 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангай түншлэл-2020” үзэсгэлэн худалдааг 2020 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Өвөрхангай түншлэл-2020” үзэсгэлэн худалдааг сайтар зохион байгуулж, гарсан үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Ганболд)-т даалгасугай.

3. Хавсралтад тусгагдсан 6,400,000 (зургаан сая дөрвөн зуун мянга) төгрөгийг “Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100925

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дугаар сарын 17-ны өдрийн 444 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: -Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: -Б.Ууганбаяр (Өвөрхангай аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)

Гишүүд: -С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

-С.Дуламсүрэн-(аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)

-Ц.Пунцаг (аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэд дарга)

-Г.Мөнхтөр- (аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)

- Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

- О.Пүрэвдорж (Арвайхээр сумын Засаг дарга)

-Ц.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга)

-Д.Батцэнгэл (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

-Д.Нансалмаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

-оОо-

09 дугаар сарын 17-ны өдрийн 09 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

"ӨВӨРХАНГАЙ ТҮНШЛЭЛ- 2020" ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Нэр, төрөл	Шагналын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	
1	Алтан намар-2020	Олон төрөл			600000	
2	Өвөрхангай түншлэл-2020 үзэсгэлэнгийн шагналууд	Өргөмжлөл	12	50000	600000	
		Мөнгөн шагнал	11	200000	2200000	
		Гранпри шагналын цом	1	100000	100000	
		Гранпри мөнгөн шагнал	1	500000	500000	
		Шилдэг зохион байгуулттай оролцсон сумын өргөмжлөл, мөнгөн шагнал	1	200000	300000	
		Хулдаасан хэвлэл				200000
		Сандал, ширээ, асар зөөх болон түрээс, ариутгалын зардал			1900000	1900000
	Нийт дүн				6400000	

-oOo-